

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН “ОЮУТОЛГОЙ БҮЛЭГ ОРДЫН АШИГЛАЛТАД
МОНГОЛ УЛСЫН ЭРХ АШГИЙГ ХАНГУУЛАХ, ХҮРТЭХ ӨГӨӨЖИЙГ
НЭМЭГДҮҮЛЭХТЭЙ ХОЛБООТОЙ БАРИМТ БИЧИГ, ҮЙЛ АЖИЛЛАГААНД
ХЯНАЛТ ШАЛГАЛТ ХИЙХ” ҮҮРЭГ БҮХИЙ ХЯНАН ШАЛГАХ ТҮР ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**

2025 оны 10 дугаар сарын 15-ны өдөр, Лхагва гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга

Хуралдааны товч тэмдэглэл: 1-2

Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл: 3-18

1. “Оюу Толгой” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүд, гүйцэтгэх удирдлагын багийн танилцуулга, мэдээллийг сонсох 4-18

Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганы “Оюутолгой бүлэг ордын ашиглалтад Монгол Улсын эрх ашгийг хангуулах, хүртэх өгөөжийг нэмэгдүүлэхтэй холбоотой баримт бичиг, үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх” үүрэг бүхий Хянан шалгах түр хорооны 10 дугаар сарын 15-ны өдөр /Лхагва гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл

Хянан шалгах түр хорооны дарга О.Батнайрамдал ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 11 гишүүнээс 7 гишүүн хүрэлцэн ирж, 63.6 хувийн ирцтэйгээр хуралдаан 14 цаг 45 минутад Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимд эхлэв.

Томилолттой: Ө.Шижир;
Чөлөөтэй: Ш.Бямбасүрэн, Б.Жаргалан.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3 дахь хэсгийг үндэслэн Түр хорооны дарга О.Батнайрамдал “Шинжээч томилох тухай” Түр хорооны тогтоолын төслийг хаалттай хэлэлцэх горимын санал гаргав.

О.Батнайрамдал: Улсын Их Хурлын гишүүн О.Батнайрамдалын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	7
Татгалзсан:	0
Бүгд:	7

100 хувийн саналаар горимын санал дэмжигдэж, хуралдаан хаалттай горимд шилжив.

Хуралдаан 14 цаг 49 минутаас 15 цаг 10 минутад хаалттай горимоор хуралдав.

Нэг. “Оюу Толгой” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүд, гүйцэтгэх удирдлагын багийн танилцуулга, мэдээллийг сонсох

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хяналт шалгалтын газрын дарга Ч.Онончимэг, мөн газрын референт Д.Мөнхтуяа, ахлах мэргэжилтэн С.Сэргэлэн нар байлцав.

Түр хорооны дарга О.Батнайрамдал Рио Тинто болон “Оюу Толгой” ХХК-иас Хянан шалгах түр хорооны хуралдаанд оролцох боломжгүй тухай захидал ирүүлснийг танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатар, С.Зулпхар нарын тавьсан асуултад Түр хорооны дарга О.Батнайрамдал, Улсын Их Хурлын Тамгын газрын Хяналт шалгалтын газрын дарга Ч.Онончимэг нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Э.Болормаа, Б.Бат-Эрдэнэ, Д.Пүрэвдаваа, С.Зулпхар, Б.Баярбаатар, П.Ганзориг, О.Батнайрамдал нар үг хэлэв.

Түр хорооны хуралдаанд “Оюу Толгой” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүд, гүйцэтгэх удирдлагын багийнхан ирээгүй тул хуралдааныг хойшлуулав./16:06/

Түр хорооны нээлттэй хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Нээлттэй хуралдаан 1 цаг 00 минут үргэлжилж, 11 гишүүнээс 8 гишүүн хүрэлцэн ирж, 72.7 хувийн ирцтэйгээр 16 цаг 06 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ХЯНАН ШАЛГАХ ТҮР
ХОРООНЫ ДАРГА

О.БАТНАЙРАМДАЛ

Тэмдэглэл хөтөлсөн:
ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 10 дугаар сарын 15-ны өдөр,
Лхагва гараг
Төрийн ордон “Их эзэн Чингис хаан” танхим
14 цаг 45 минут.

ХЯНАН ШАЛГАХ ТҮР ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

О.Батнайрамдал: Эрхэм гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая. Оюу толгой бүлэг ордын ашиглалтын асуудлаарх Хянан шалгах түр хорооны гишүүдийн ирц бүрдсэн тул 2025 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье. Хуралдааны ирцийг та бүхэндээ танилцуулъя. Өнөөдрийн хуралдаанд Сархадын Зулпхар, Баярмагнайн Баярбаатар, Пүрэвжавын Ганзориг, Отгоншарын Батнайрамдал, Даваахүүгийн Пүрэвдаваа, Энхбатын Болормаа, Бат-Өлзийн Бат-Эрдэнэ гээд, Бат-Эрдэнэ гишүүдээр нийт ирц 63,6 хувьтайгаар ирц бүрдсэн байна.

Өнөөдрийн хуралдаанаар дараах асуудлыг хэлэлцэнэ. 1 дүгээрт, Шинжээч томилох тухай тогтоолын төсөл. 2 дугаарт, Оюу толгой компанийн танилцуулга, Оюу толгой компанийн гүйцэтгэх удирдлага, төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг дуудсан байгаа. 3 дугаарт, Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 67 дугаар захирамжаар байгуулагдсан Оюу толгой төслийн санхүүжилтийн хүүгийн зохистой байдлыг хянан үзэх, өөрчлөх асуудлаар хөрөнгө оруулагч талтай хэлэлцээ хийж, санал боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн явцын мэдээллийг сонсох. 4 дүгээрт, Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 73 дугаар захирамжаар байгуулагдсан Стратегийн ач холбогдол бүхий Оюу толгой бүлэг ордын талбайн хил зааг дотор ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшдэг Онтрэ компанийн хувьцааны төрийн эзэмшлийн хувь хэмжээг Монгол Улсын Үндсэн хууль, Ашигт малтмалын тухай хууль тогтоомжид нийцүүлэн тогтоох талаар хөрөнгө оруулагч талтай хэлэлцээ хийж, холбогдох бусад асуудлыг Улсын Их Хуралд танилцуулах үүрэг бүхий ажлын хэсгийн явцын мэдээллийг сонсох гэсэн 1, 2, 3, 4 асуудал өнөөдөр хэлэлцэх нь.

Хэлэлцэх асуудалтай өөр саналтай гишүүн байна уу? Байхгүй байна. Хэлэлцэх асуудалдаа батлаад, оръё. Өнөөдрийн хуралдаанаар Шинжээч томилох асуудал хаалттай явагдана. Бусад асуудал бүгдээрээ нээлттэй явагдахаар байгаа. Өнөөдрийн хуралдаанаар хэлэлцэх асуудал 1 дүгээрт Шинжээч томилох нь түр хорооны дотоод асуудал бөгөөд Хянан шалгах түр хорооноос томилогдон ажиллахад шинжээчид хөндлөнгөөс нөлөөлөх магадлалтай учир тус тогтоолын төслийг хэлэлцэхэд хаалттай хуралдах горимын саналыг гаргаж байна.

Иймд Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3 дахь хэсгийг үндэслэн хуралдааныг түр хаалттай горимд шилжүүлэх саналаар санал хураалт явуулъя. Гишүүддээ хэлэхэд шинжээч томилох эхний асуудал л хаалттай горимтой, бусад нь бүгдээрээ нээлттэй явна гэдгийг дахин хэлье. Гишүүд санал хураалтад бэлдье. Санал хураалт. Нийт гишүүдийн 100 хувийн саналаар горимын санал дэмжигдэж, хуралдааныг хаалттай горимд шилжүүлнэ үү.

Тийм, тийм, яг үнэн. Дараагийн асуудалдаа орцгооё. Хуралдаан нээлттэй, нээлттэй явж байгаа биз дээ, тийм ээ?

Нэг. “Оюу Толгой” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүд, гүйцэтгэх удирдлагын багийн танилцуулга, мэдээллийг сонсох

2 дугаар асуудал Оюу толгой компанийн танилцуулга, Оюу толгой компанийн гүйцэтгэх удирдлага болон Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүд. Хүрэлцэн ирсэн 1 ч гэсэн хүн байна уу, оруулчих уу?

Эрхэм гишүүддээ, та бүхэндээ дахиад л нэг захиа харуулах нь дээ. Оюу толгой компанийн, Оюу толгой компани Монгол Улсын Засгийн газар 34 хувийг эзэмшдэг, төрийн өмчийн оролцоотой, Монгол Улсад бүртгэлтэй хуулийн этгээд. Бидний Хянан шалгах түр хорооны үндсэн сэдэв Онтрэтэй холбоотой асуудал болон зээлийн хүүтэй холбоотой асуудал хоёулаа Оюу толгой гэсэн энэ компанийн үйл ажиллагаатай шууд холбоотой ер нь, гол компани нь Оюу толгой шүү дээ. Тэгээд Оюу толгой компанийг 2 удаа танилцуулга хийнэ үү гэж Хянан шалгах түр хорооноос Улсын Их Хурлын албан ёсны товд ороод, дээрээс нь тусгайлан 2 удаа Хянан шалгах түр хорооны даргын зүгээс хуралдаанд хүрэлцэн ирнэ үү гэсэн албан тоотыг явуулсан. Энэ удаа ч гэсэн бас хуралдаан эхлэхээс өмнөх өдөр буюу өчигдөр, 2025 оны 10 сарын 14 гэсэн хаягтай Оюу толгой, Рио Тинто гэсэн бланк дээр энэхүү хуралд, Хянан шалгах түр хорооны хуралдаанд оролцох боломжгүй гэсэн хариуг захиагаар ирүүлсэн байна.

Энэ Улсын Их Хурлын Хянан шалгах түр хороо үндсэн 2 сэдвийн хүрээнд Улсын Их Хурлын хянан шалгах тухай хууль, Улсын Их Хурлын дэгийн тухай хууль, холбогдох хууль, тогтоол дээр бид тухайн сэдвийн хүрээ хязгаарт хамааралтай хэнийг ч дуудах эрхтэй. Өнөөдөр ингээд 34 хувь төрийн эзэмшил компани Оюу толгой компани 2 дахь удаагаа ирэхээс татгалзсан байна. Та бүхэн харсан байх, олон нийтэд бидэнд бараг захиа ирүүлэхээсээ өмнө олон нийтийн мэдэгдэл гаргасан байсан. Тэр олон нийтийн мэдэгдэл хүлээж авсны дараа миний бие албан ёсоор тэднийхээс ирсэн Улсын Их Хурлын Хянан шалгах түр хорооны даргад хаягласан ийм захиаг ирүүлсэн байна. Энэ дээр нууц дараагүй байна. Нууцын тэмдэггүй учраас Оюу толгойгоос ирж байгаа бүх юм нууцтай байгаа, албан тоотууд хүртэл нууцтай. Тэгэхээр энэ нууц дараагүй энэ Хянан шалгах түр хорооны даргад хуралдаанд ирэх боломжгүй гэсэн захиаг би та бүхэндээ уншиж өгье гэж бодож байна.

Өнөөдөр бид парламент дээр Монгол Улсын 3,5 сая иргэнийг бид төлөөлөөд сууж байгаа. Тэр дундаа Хянан шалгах түр хороо бол Улсын Их Хурлын парламентын хяналтын механизмыг ажиллуулж байгаа үндсэн чиг үүрэгтэй Хянан шалгах түр хороо. Тэгэхээр энд 2 дахь удаагаа ирэх боломжгүй гэсэн хариугаа ингэж тайлбарласан байна.

Монгол Улсын Их Хурлын Хянан шалгах түр хорооны дарга О.Батнайрамдал Танаа, өчигдөр ирсэн цагаа 2025 оны 10 сарын 14-нд гэж хаягласан байна. Оюу толгой, Рио Тинто гээд 2 компаниас хоёулан дээр нь хоёулангийнх нь логотойгоор ирсэн байна. Удахгүй болох Хянан шалгах түр хорооны хуралтай холбоотойгоор 2025 оны 10 сарын 10-ны өдөр ирүүлсэн таны албан бичгийг талархан хүлээж авлаа. Оюу толгой компани болон Рио Тинто нь Түр хорооны үүргийг хүндэтгэж, Оюу толгой компанитай холбоотой асуудлаар харилцан яриа өрнүүлэхийг ач холбогдолтой санал нийлж байна гэсэн байна. 2025 оны 10 сарын 15-ны өнөөдрийн хуралдаанд оролцуулах саналыг нухацтай тунгааж үзсэний эцэст тус хуралд оролцох оролцохгүй байх шийдвэрийг гаргаснаа үүгээр мэдэгдэж байгааг хүлээн авахыг хүсье гэсэн байна.

Сүүлийн үеийн хурдацтай өөрчлөгдөж буй нөхцөл байдал, улс төрийн хурцадмал уур амьсгалаас шалтгаалж бид энэхүү шийдвэрийг гаргахаас аргагүй байдалд хүрсэн болно. Мөн ойрын өдрүүдэд олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр үндэслэлгүй буруутгах, хэт хурцаар шүүмжлэх, улс төрийн шинжтэй мэдэгдэл хийх явдал давамгайлах болсон нь бидний зүгээс ихэд санаа зовниж байна. Ялангуяа хууль бусаар мөрдүүлж байгаа болон хувийн аюулгүй байдалдаа санаа зовж байгаа тухай олон нийтэд хийсэн Таны, намайг хэлж байх шиг байна л даа, мэдэгдэл нөхцөл байдал ямар ноцтой байгааг харуулж байна. Миний хийсэн мэдэгдэлтэй холбоотойгоор ирэхгүй гэсэн шалтгаанаа тайлбарлаж байх шиг байна.

Түүнчлэн хувийн хэвшлийн томоохон байгууллагууд руу чиглэсэн ташаа мэдээлэл, үндэслэлгүй буруутгасан дайралтууд гарах нь олширч, тэр бүү хэл зохион байгуулалттай бүлэг этгээдүүд Оюу толгой компанийн байранд ирж, зориуд эмх замбараагүй байдал үүсгэж байна. Энэ бүх нөхцөл байдал нь манай ажилтнуудын аюулгүй байдал, нэр хүнд, амар амгалан байдалд ихээхэн эрсдэл учруулж байна. Энэ утгаараа тус хорооны 7 хоногийн тутмын хуралд биечлэн оролцоход бидний хувьд үр дүнтэй бөгөөд аюулгүй орчин бүрдэхгүй гэж үзэж байна гэнэ. Аюулгүй орчин Оюу толгойн хувьд энэ парламентын танхимд ирж суугаад, бидний асуултад хариулахад аюулгүй орчин бүрдэхгүй байна гэж хариулсан байна. Хуралд уригдсан хүмүүсийн талаарх олон нийтэд ташаа ойлголт төрүүлж, тэдгээр хүмүүсийн нэр хүндэд үндэслэлгүйгээр халдах эрсдэл гарах вий хэмээн болгоомжилж байна.

Иймд ажилтнуудынхаа аюулгүй байдлыг нэн тэргүүнд тавьж, эрсдэлд оруулахгүй байх үүднээс илүү тогтвортой, хүндэтгэлтэй орчин нөхцөл бүрдэх хүртэл Оюу толгой болон Рио тинто бүх захидал харилцаагаа хувь хүний нэр дурдахгүйгээр явуулахаар боллоо. Бид хувьцаа эзэмшигчийн зээлийн хүү болон Онтрэгийн тусгай зөвшөөрлийн шилжүүлгийн асуудлын зарчмын шийдэлд чиглэсэн яриа хэлэлцээр хийх зорилгоор Засгийн газрын холбогдох ажлын хэсгүүдтэй хамтран ажиллах үүрэг амлалтаа хэвээр хадгалж байна.

Мөн Эрдэнэс Оюу толгой компанийн 2025 оны 10 сарын 13-ны өдөр ирүүлсэн 01 258 тоот албан бичгийн дагуу Оюу толгойн санхүүжилтийн хүүгийн талаарх 2 талын хэлэлцээг Сангийн сайд Жавхлангаар ахлуулсан ажлын хэсэгтэй 10 дугаар сарын сүүлээр хийхээр төлөвлөж байна. Бид Оюу толгойн урт хугацааны амжилт, Монголын ард түмэнд үзүүлэх үр өгөөжийг хангахын тулд хүндэтгэлтэй, ил тод, ирээдүйд чиглэсэн харилцан яриа өрнүүлэх хамгийн зөв зам гэж итгэсээр байна. Энэхүү нөхцөл байдлыг ойлгож байгаа Танд талархаж бүх талын аюулгүй байдлыг хангаж, ирээдүй бодит үр дүнг хүргэх боломжтой орчин хэлэлцүүлэг хийхэд бид нээлттэй хэвээр байх болно гэсэн ийм албан тоотыг Оюу толгой болон Рио Тинто компани хамтарсан захиагаараа явуулсан байна.

Өнөөдөр ингээд Оюу толгой компани дахиад Хянан шалгах түр хорооны хуралдаанд ирэх боломжгүй гэдэг 2 хуудас захиагаар хүргүүлсэн байна. Үүнтэй холбоотойгоор асуулт асуух, үг хэлэх гишүүд нэрсээ өгье? Асуулт хэнээс асуух юм. Тэгье, асуулт асуух гишүүд. Тусдаа. Болормаа гишүүнээр тасалъя. Баярбаатар гишүүний микрофон.

Б.Баярбаатар: Гишүүддээ өдрийн мэнд хүргэе. Өнгөрсөн удаагийн хурал дээр ирээгүй, энэ нөхдүүд чинь ингээд Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа, Монгол Улсад бүртгэлтэй хуулийн этгээд байж иймэрхүү байдлаар хандлага

гаргана гэдэг буруу л юм л даа. Тэгээд энэ сүүлд ирүүлсэн бичиг дээр энэ Оюу толгой байрны ХХК-ийн байранд ирж эмх замбараагүй байдал үүссэн нь бидэнд ер нь ямар хамаатай юм бэ? Тэрийг чинь шалгаж байцаадаг хууль хяналтын байгууллага нь өөрсдөө байж байгаа.

Тэгээд хамгийн гол асуудал энэ манай Төрийн ордон чинь аюулгүй байдлаа алдчихсан юм уу? Энд бид чинь хурлаа хийгээд, үйл ажиллагаагаа явуулаад байдаг. Энэ Оюу толгой чинь бид энэ Төрийн ордонд ороод ирвэл, эсхүл манай Түр хорооны гишүүд нь Оюу толгой компанийнхныг сүрдүүлчихсэн юм уу? Орж ирээд л ингэнэ шүү, тэгнэ шүү гээд, энэ дээр чинь тийм л юм биччихсэн байна шүү дээ. Тэгээд хуралд уригдсан хүмүүсийн талаар олон нийтэд ташаа ойлголт төрүүлж, тэдгээр хүмүүсийн нэр хүндэд үндэслэлгүйгээр халдах эрсдэл гарах вий хэмээн болгоомжилж байна. Хорооны 7 хоног тутмын хуралд биечлэн оролцох нь бидний хувьд үр дүнтэй бөгөөд аюулгүй орчинд бүрдэхгүй байна гэж байгаа байхгүй юу. Энэ яах вэ тэгээд ийм байдаг юм байж.

Түр хорооны даргалагчаас манай Түр хороо чинь ер нь хэзээ хуралдаж, энэ шийдвэр юмнуудаа гаргах юм бэ? Энэ чинь ингээд ямар шийдвэр гарах юм бэ? Засгийн газарт чиглэл өгнө гэж ойлгоод байгаа. Хэрвээ энэ Засгийн газарт чиглэл өгөхөөр бол бид ер нь хурдан хуралдаж энэ чиглэлээ өгвөл яасан юм бэ цаг хугацаандаа амжуулж. Одоо энэ 2019 оны 11 сарын 21-ний өдрийн энэ 92 дугаар Монгол Улсын Их Хурлын тогтоол 92 дугаар тогтоол. Эндээс үүдээд 2021 оны 12 сарын 30-ны өдрийн 103 дугаар Их Хурлын тогтоол. Энэ 2-оос үүдээд улбаалаад цаашаагаа 22 оны 1 сарын 26-ны өдрийн Монгол Улсын Засгийн газарт чиглэл өгөх тухай Түр хорооны тогтоол ийм 3 бичиг баримт дээр ер нь Түр хорооны даргаа ямар анализ хийсэн юм бэ та?

Эндээс хэрэгжсэн юм нэг ч алга байна шүү дээ. Одоо эндээс ингээд жишээлбэл хар даа, энэ дээр 103 дугаар тогтоол дээр Эрдэнэс Оюу толгой ХК-д нэмэлт өр үүсгэхгүй байх, Оюу толгой ХХК-д хувьцаа эзэмшигчид болон гуравдагч этгээдээс нэмэлт зээлийн санхүүжилт авахгүй байх. Энэ байхгүй. Тэр далд уурхайн юуг ТЭЗҮ-г бараг дахиж хий гээд ингээд хуульд нийцүүл гээд энэ Түр хорооны тогтоол дээр ингээд биччихсэн байна. Энэ мөрдөгдөөгүй. Эндээс ерөөсөө энэ 3 тогтоолоос ерөөсөө мөрдөгдсөн, хэрэгжсэн юм ерөөсөө байхгүй байгаад байгаа. Тэгээд бид ингээд өнөөдрийн нөхцөл байдлыг бол ойлгоод байгаа. Тэр өдөрт хэдэн тэрбум төгрөгийн өр зээл хүү төлж байна энэ тэр гэсэн асуудлыг бол ойлгоод байгаа. Зүгээр өмнө нь ингээд хийчихсэн 19 оноос хойш хийчихсэн эдгээр энэ 3 тогтоолыг ер нь яах вэ? Энэ Их Хурал.../минут дуусав/

О.Батнайрамдал: Баярбаатар гишүүний хэлж байгаа үнэн. Оюу толгойн гэрээ 2009 онд зурагдсанаас хойш 16 жилийн туршид маш олон асуудлууд дагуулж ирсэн. Далд уурхайн бүтээн байгуулалтын явцад ч гэсэн менежментийн алдаа гарсан шүү дээ. Тэрнээс болж зардал өссөн, хугацаа хожигдсон. Яг үнэнийг хэлэхэд тэр далд уурхайн бүтээн байгуулалт тэнд Рио Тинтогийн менежментийн алдаа гарснаас болж зардал 1,9 тэрбум доллароор хэтэрч, хугацаа 20-оос 30 сараар хойшилсон гэдэг Америкийн Нэгдсэн Улсын холбооны шүүх дээр Рио Тинтог шүүгдсэн шүүх дээр Рио Тинто ялагдсан шүү дээ. Энэ дээр Оюу толгойгоо хөндлөнгийн Ай Си Жи гээд компанийн хөндлөнгийн мэргэжлийн дүгнэлт бас гарсан байдаг. Энэ болгон дээр зээл гарсан, энэ болгоны зээлийн хүүг өнөөдөр бид төлж байгаа шүү.

Энэ асуудлыг цогцоор нь шийдье, хувь нийлүүлэгчдийн зээлийг, зээлийн хүүг нь өөрчлөх боломж бидэнд гэрээгээр олгочихсон байна. Энийг ингээд хамтдаа суугаад өөрчилье. Энэ дээр үйл процесс дээр хяналт шалгалт хийх Хянан шалгах түр хороо байгуулагдаад 3 сарын хугацаа өнгөрсөн байна. 89 гишүүн гарын үсэг зурж, парламентын 70 хувь нэгдэж, өнөөдрийн Хянан шалгах түр хороог байгуулсан. Хянан шалгах түр хороо гэдэг бол улсын их, парламентын Улсын Их Хурлын дэгийн тухай хууль дээр ч маш ойлгомжтой заасан. Улсын Их Хурлын хэвийн үйл ажиллагаа явуулах үндсэн чиглэлийн нэг нь Хянан шалгах түр хороо мөн шүү дээ. Гэтэл өнөөдөр Хянан шалгах түр хорооны хэвийн үйл ажиллагаанд 2 дахин, 2 удаагаа давтан долоо хоног тутам ирж чадахгүй гэснээрээ хэвийн үйл ажиллагаанд доголдол үүсэх хэмжээнд л хүрч байна л даа.

Таны хэлсэн Улсын Их Хурлаар батлагдсан 92 дугаар тогтоол, 103 дугаар тогтоол батлагдсан. Хамгийн сүүлд 2021 онд батлагдсан 103 дугаар тогтоолоос үндсэн 6 зүйлээр Засгийн газар луу чиглэл өгсөн боловч 2,3 тэрбум долларыг тэглэснээс өөр бусад нэг нь ч одоог хүртэл хэрэгжиж дуусаагүй, хэрэгжиж байгаа гэсэн дүгнэлтийг Эрдэнэс Оюу толгой компани танилцуулгаараа бидэнд ирж хийсэн байдаг. Гэтэл өнөөдөр Хянан шалгах түр хороо яг эд дундаа явж байхад ингээд хэвийн үйл ажиллагаа явуулахад доголдол үүсгээд ингээд эхэлж байна. Энэ өөрөө ноцтой асуудал. Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хууль дээр өөрөө энэ чинь санкцтай шүү дээ.

Бид зүгээр нэг хөндлөнгийн байгууллагыг дуудаагүй, 34 хувийн Монгол Улсын эзэмшил, Монгол Улсад бүртгэлтэй аж ахуйн нэгжээ ирж танилцуулга хийгээч л гэж дуудсан. Баярбаатар гишүүнд нэмэлт тодруулга.

Б.Баярбаатар: Би нэг асуулт байна. Энэ 34 хувийн эзэмшдэг энэ зарчмаар дэлхийн бусад улсууд яг ийм гэрээ байгуулсан ийм өнгөрсөн хугацаанд ийм өөр улс байдаг юм уу 1 дүгээр асуулт?

2 дахь нь яах вэ зүгээр ер нь энэ 22 оны 1 дүгээр сарын энэ өдрийн энэ Түр хорооны Засгийн газарт чиглэл өгөх тухай тогтоолын энэ дээр 1.1 дээр Монгол Улсын Их Хурлын 2008 оны 12 сарын 04-ний өдрийн 40 дүгээр тогтоол, 2009 оны 7 дугаар сарын 16-ны өдрийн 57 дугаар тогтоолд нийцээгүй Хөрөнгө оруулалтын гэрээ, Хувь нийлүүлэгчдийн гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж, дахин тодотгох гэж байгаа юм. Энэ л өнөөдөр бидний хийгээд байгаа ажил байна. Тэгээд дараа нь тэр далд уурхайн бүтээн байгуулалт, санхүүжилтийн төлөвлөгөө, далд уурхайн бүтээн байгуулалт, санхүүжилтийн нэмэлт төлөвлөгөө, менежментийн гэрээ нь Монгол Улсын хууль тогтоомж зөрчсөн гэж дүгнэсэн тул бүхэлд нь цуцалж, хүчингүй болгох гэсэн нэг эдгээр зүйлүүд байж байгаа. Тэгээд цаашаагаа энэ чинь нийтдээ 8 заалт байгаа. Энийг ингээд тухайлан бүүр ингээд үг, үсэггүй л.../минут дуусав/

О.Батнайрамдал: Тийм, тийм. Ер нь таны хэлж байгаа зөв. 103 дугаар тогтоол одоо хүртэл хэрэгжих ёстой. Монгол Улсын Засгийн газар 103 дугаар тогтоолын хэрэгжилтийг тухай бүр дээр нь орсон пойнт болгон дээр нь хэрэгжилтийг заавал хангах ёстой. Хянан шалгах түр хорооны үндсэн хүрээ хязгаарт Онцгой лиценз, эзэмшил, төрийн эзэмшлийн хувь хэмжээг тогтоох үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх, зээл, хувь нийлүүлэгчдийн зээлийн хүү. Тэгэхээр энэ 2 асуудлаар хянан шалгах үйл ажиллагаа бид хамгийн гол нь энэ ямар нэгэн доголдолгүйгээр, нөлөөлөлгүйгээр үргэлжлэх ёстой. Улс төрийн ямар нөхцөл, ямар ч нөхцөл байдал гарч болно. Гэхдээ Оюу толгойн Хянан шалгах түр хорооны ажил хэзээ ч доголдох ёсгүй. Санаатайгаар хууль зөрчиж, өөрсдөө доголдуулж болохгүй шүү дээ.

Асуудлыг бид шийдье гэж байгаа юм. Энэ Хянан шалгах түр хороо ажиллаад, сүүлийн 16 жилийн турш болсон үйл процессыг бид ойлгоё, энэ дээр хяналт шалгалт хийе гэж байгаа юм. Энэ дээр бол төрийн байгууллагууд болон холбогдох байгууллагууд, төрийн эзэмшлийн, төрийн жишээлбэл Оюу толгойгоос эхлээд бүгдээрээ энэ дээр бидэнтэй хамтарч ажиллах ёстой. Энэ өөрөө хуулийн зохицуулалттай юм. Тэгээд бид өөрсдөө ирж чадахгүй нь гэдгээ бараг бид захианаасаа өмнө олон нийтийн мэдэгдлийг фэйсбүүкээр тавиад ингээд явж байж болохгүй.

Энэ Хянан шалгах түр хорооны асуудлаас даваад халиад явчихлаа шүү. Энэ бол Монгол Улсын парламентын асуудал болсон. Өнөөдөр Монгол Улсын парламент бид хаврын чуулганаар 7 сарын 2-нд орж, Улсын Их Хурлын хянан шалгах түр хороо байгуулахыг 89 гишүүний гарын үсэгтэйгээр байгуулсан. Энэ 89 гишүүний асуудал давхар яригдаж байгаа юм. 89 гишүүн буюу парламентад суудалтай 5 намын дийлэнх олонх нь дэмжиж байгуулагдсан Хянан шалгах түр хорооны ажил ямар нэгэн доголдолгүйгээр хэвийн явах ёстой. Энийг Монгол Улсын 3,5 сая иргэн бүгдээрээ чих тавин харж байгаа хэн доголдуулж байна, хэн үүнд халдах гэж оролдож байна. Тэрнээс биш бид асуудлыг шийдье гэж байгаа шүү дээ. Энэ 2 асуудал дээр заавал шийдэл гарах ёстой. Энэ 2 асуудал дээр Монгол Улс заавал шийдэл гаргах ёстой. Зээлийн хүү буурах ёстой. Онтрэ дээр Монгол Улсын Үндсэн хуулиар олгогдсон, Ашигт малтмалын хуулиар олгогдсон эрх нь хэрэгжих ёстой, дотоодын хууль тогтоомж хэрэгжих л ёстой гэж байгаа юм. Зулпхар гишүүний микрофоныг өгье.

С.Зулпхар: Түр хорооны дарга, эрхэм гишүүд, ажлын албаны энэ өдрийн мэндийг айлтгая. Асуулт байна. Яах вэ мэдэж байгаа ч гэсэн зориуд хуралдаандаа тэмдэглүүлэх үүднээс асуулт асууж байгаа юм. 1 дүгээрт энэ Оюу толгой компани Монгол Улсад бүртгэлтэй компани мөн үү гэсэн ийм асуулт байна?

2 дахь асуулт энэ Оюу толгой компани Монголын төрийн өмчийн оролцоотой ийм компани мөн үү гэдэг 2 дахь асуулт байна?

3 дахь асуулт хэрвээ төрийн өмчийн оролцоотой компани мөн бол бид тэгж ойлгож байгаа шүү дээ. Төрийн эрх барих дээд байгууллага тодорхой чиг үүргийнхээ дагуу, эрх, үүргийнхээ дагуу энэ компанийн эрх бүхий этгээдүүдийг субъектүүдийг дуудаж мэдээлэл авах, тайлбар авах эрхтэй юү гэдэг ийм 3 дахь асуулт байна?

4 дэх асуулт Хянан шалгах түр хороо Улсын Их Хурлын тухай хуулиар байгуулагдсан Улсын Их Хурлын зохион байгуулалтын бүтцийн хувьд хянан шалгах үүргийнхээ, чиг үүргийнхээ хувьд тодорхой асуудлаар эрх бүхий субъектээс мэдээлэл авах зорилгоор дуудан ирүүлэх, эсвэл урьж ирүүлэх ийм үйл ажиллагаанд зориудаар саад учруулж, 1 биш, 2 удаа ирээгүй нөхцөлд ямар энэ дээр хариуцлага яригдах вэ гэдэг ийм 4 дэх асуулт байна?

Дараагийн асуулт, 5 дахь асуулт. Рио Тинтогийн энэ ирүүлсэн Оюу толгой компанийн ирүүлсэн энэ бичиг байна л даа таны нэр дээр. Энэ дээр ийм асуудал ярьсан байна. Ялангуяа хууль бусаар мөрдүүлж байгаа болон хувийн аюулгүй байдалдаа санаа зовж байгаа тухай олон нийтэд хийсэн таны мэдэгдэл нөхцөл байдал ямар ноцтой байгааг харуулж байна гэсэн байна. Тантай холбоотой асуудал Оюу толгойн хувьд ямар нэгэн мэдээлэл өгөхөд яаж нөлөөлж байна, эсхүл ямар

байдлаар саад учруулж байна гэж үзэж болохоор байгаа энэ дээр таны байр суурийг сонсож байгаа шүү зориуд?

6 дахь асуулт энэ дээр бичсэн байна л даа. Түүнчлэн хувийн хэвшлийн томоохон байгууллагууд руу чиглэсэн ташаа мэдээлэл, үндэслэлгүйгээр буруутгасан дайралтууд гарах нь олширч, тэр бүү хэл зохион байгуулалттай бүлэг этгээдүүд Оюу толгой ХХК-ийн байранд ирж, зориуд эмх замбараагүй байдал үүсгэж байна гэж байгаа юм. Ажлын хэсгийнхэн энэ цагдаагийн байгууллагаас ийм байдал үүссэн эсэхийг тодруулсан уу? Яг ийм байдал үүссэн, ийм ноцтой нөхцөл байдал байгаа юу гэдэг ийм асуулт байна?

7 дахь асуулт. Манай Засгийн газраас байгуулагдсан ажлын хэсгүүд байгаа юм. Засгийн газрын ажлын хэсэг байгуулагдаж байгааг бид ингээд хийгээд явж байгаа гэдэг ийм зүйл хэлсэн байна. Бид энэнээс өөрөөр ямар нэгэн асуудлыг тодруулах зорилго тавиагүй байх гэж би бодож байгаа юм. Энэ ажил явдгаараа явж байгаа, энэ ажил яаж явж байна гэж би тодруулах зорилготой байгаа болохоос биш өөр юм асуух гэгүй шүү дээ. Тэгэхээр яагаад бидний асуух гэсэн зүйл дээр яг энэнтэйгээ адилхан хариулт өгч болохгүй байгаа юм бол гэсэн ийм асуултыг өөрсдөө.../минут дуусав/

О.Батнайрамдал: Зулпхар гишүүний асуултад хариулъя. Оюу толгой төсөл дээр 2009 оны бид Хөрөнгө оруулалтын гэрээ байгуулахдаа Монгол Улсын Засгийн газар нэг ёсондоо Монгол, Монголын тал 34-ийг эзэмшинэ гэдгээ бид гэрээгээрээ баталгаажуулсан. Тэгэхээр бид Оюу толгой бол, Оюу толгой компани төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд мөн шүү дээ. Бид 34 хувь эзэмшдэг. 34 хувь эзэмшдэг төрийн өмчийн оролцоотой компани дээр энэ дээр бид Онтрэ болон зээлийн хүү чинь энэ Оюу толгойтой холбоотой асуудал шүү дээ. Тэгээд яг үндсэн ирж танилцуулгаа тавьж, асуудлаа ярих ёстой компани маань өөрөө ингээд хүрэлцэн ирэх боломжгүй гэж Улсын Их Хурлын Хянан шалгах түр хороонд ингээд албан бичгээр хандаад байна л даа. Энийг яг үнэнийг хэлэхэд яг яаж ойлгохоо би мэдэхгүй байна. Яг яагаад ирэхгүй байгаа юм? Мэдэхгүй, надаас л асууж байна.

Өнөөдөр Оюу толгой, өөр хүн ирэхгүй болохоор. Онончимэг дарга хариулах уу, та энэ хуулийнх нь дагуу. Тэгэхээр Улсын Их Хурлын Тамгын газраас, тийм, харин тийм. Тэгэхээр харин тийм, өнөөдөр ингээд гишүүдийн асуултад би өөрөө ингээд хариулж байгаа нь аягүй утгагүй байна. Уг нь Оюу толгой компани өөрсдөө ирээд та бүхний асуултад хариулах ёстой байсан. Зөв. Улсын Их Хурлын Тамгын газраас бид ажлын хэсэг байгаа. Тэгэхээр ажлын хэсгээс яг энэ хууль Зулпхар гишүүний асуусан яг хууль дээр ямар хуулийн этгээд өнөөдөр ирэх ёстой юм уу, үгүй юм уу? Өнөөдөр яг ийм асуулт асууж байгаадаа харамсаж байна яг үнэнийг хэлэхэд. Тэгэхээр энэ дээр та нэмэлт хариулт өгчих. Онончимэг даргын микрофон.

Ч.Онончимэг: Зулпхар гишүүний асуултад хариулъя. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3.8 дахь заалт дээр Байнгын хорооны нийтлэг бүрэн эрхэд чуулганаар хэлэлцэх асуудлаар болон хууль тогтоомжийн биелэлтийн талаар судалгаа, тайлан, мэдээ, бусад баримт бичгийг холбогдох байгууллага, албан тушаалтнаас гаргуулан авах, тэдний мэдээллийг сонсох гэж заасан байдаг. Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 34.1-д болохлоор Түр хороо нь Байнгын хорооны нийтлэг бүрэн эрхийг эдлэхээс гадна дараах нийтлэг бүрэн эрхийг эдэлнэ гээд дахиад нарийвчлаад заачихсан байгаад байгаа. Тийм учраас Байнгын хорооны нийтлэг бүрэн эрхийг хэрэгжүүлэх Түр хороо

хэрэгжүүлэх эрхтэй учраас холбогдох албан тушаалтан, байгууллага, албан тушаалтан Түр хороонд мэдээлэл хийх эрх нь үүсчхэж байгаа юм.

Хяналт шалгалтын тухай хуулийн 57 дугаар зүйлийн 1 дэх хэсэг дээр Улсын Их Хурлаас, би яг хараадахъя. Холбогдох албан тушаалтан энэ хуульд заасан нотлох, энэ хуульд заасан үүргээ, та түр хүлээж байгаарай. 57.1-д энэ хуулийн холбогдох зүйл, заалт, хэсэг, заалтаар холбогдох албан тушаалтан оногдуулсан үүргийг хугацаанд нь биелүүлээгүй, эсхүл зохих ёсоор биелүүлээгүй нь Улсын Их Хурлын хяналт шалгалтыг тасалдуулсан бол Улсын Их Хурлын тухай хуулийн 21.25-д зааснаар парламентыг үл хүндэтгэсэн гэж үзэх ийм үндэслэл болж байгаа.

Яг энэ холбогдох яг энэ хуулийн заалтаар бол Төрийн албаны тухай хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээнэ гэж байгаа юм. Зөрчлийн тухай хуулийн 15.33 дугаар зүйлийн 2 дахь хэсэг дээр Монгол Улсын Хянан шалгах түр хорооны дуудсанаар хүрэлцэн ирэхээс зориуд зайлсхийсэн бол зөрчил, парламентыг үл хүндэтгэсэн гэдэг зөрчилд тооцогдож байгаа юм.

О.Батнайрамдал: Ер нь хууль дээр маш ойлгомжтой байгаа. Зөрчлийн тухай хуулийн бүхэл бүтэн 15.33 дугаар зүйл парламентыг үл хүндэтгэсэн асуудалтай холбоотойгоор байдаг. Тэн дээр зориуд зайлсхийсэн гэж байгаа шүү дээ. Зориуд зайлсхийсэн. Тэгэхээр өнөөдөр яг үнэнийг хэлэхэд бид парламент дээр ирэхгүй тохиолдолд ямар санкц байдаг вэ гээд яриад сууж байгаа нь үнэхээр харамсалтай хэрэг байна. Ирээд л мэдээллээ хийгээд л, хамтарч ажиллах ёстой. Монгол Улсын парламентыг хүндэтгэх ёстой. Болормаа гишүүний микрофоныг өгье.

Э.Болормаа: Түр хорооны гишүүддээ энэ өдрийн мэнд хүргэе. Асуулт асуухгүй, санал хэлчихье гэж бодож байна. Бүгдээрээ хаана хаанаа жоохон ажил хэрэгч хандъя. Энэ захидал бараг нэг улс төрчийн захидал шиг л иймэрхүү захидал харагдаж байна. Ер нь энэ Улсын Их Хурлаас гарсан Хянан шалгах түр хорооны 2 зорилго бол Онтрэ-н асуудал болон зээлийн хүүг бууруулах. Засгийн газар энэ дээрээ ажлын хэсэг байгуулаад явж байгаа.

Яагаад энэ Улсын Их Хурлаас буюу олон нийтийг иргэдийг төлөөлж байгаа энэ байгууллага үүн дээр Хянан шалгах түр хороо байгуулж байна вэ гэхээр энд олон нийтэд мэдээлэл нээлттэй байх ёстой, бид өмнөхийг ухаж сөхөх тохичихоос илүүтэйгээр урагшаа харсан маш ажил хэрэгчээр энэхүү төслийг хэрхэн Монгол Улсад илүү үр өгөөжтэй болгох тал дээр энэ ажлын хэсэг, Хянан шалгах түр хороо ажиллаж байгаа гэж би хувьдаа үзэж байгаа. Гэтэл энэ бие биен рүүгээ хуруу чичилсэн, бараг бид зохион байгуулалттай энэ чинь бүлэг этгээдүүд Оюу толгойн байран дээр зориуд авчирсан мэт иймэрхүү бичиг ирнэ гэдэг аягүй харамсалтай байна.

Энэ бичиг дээр нэг зүйлийг онцолж хэлмээр байгаа нь Оюу толгой болон Рио Тинто гэсэн байна. Тэгээд би Оюу толгой төсөл маань Монгол Улсын Засгийн газар болон Рио Тинто компани хамтран явуулж байгаа төсөл, хөрөнгө оруулалтын гэрээтэй. Тэгэхээр өнөөдөр өглөө Сангийн сайдын Засгийн газрын хуралдааны дараах мэдээлэл дээр Рио Тинто компанийн төлөөллүүд хэлэлцээрт ирэхээр Монголд ирж байгаа гэж ойлгож байна. Тэгэхээр бид Оюу толгой гэж шахахаас илүүтэйгээр яг энэ хэлэлцээрт орох Рио Тинто компани өнөөдөр энэ бичиг дээр анх удаа яагаад компанийнхаа лого тавьсан бэ, энэ компанитай бид хэлэлцэх ёстой юм биш үү гэсэн ийм бодол төрж байна.

Тэгээд Хянан шалгах түр хорооныхоо гишүүддээ, магадгүй энийг үзэж байгаа олон нийт энэ захидал дээр хамгийн ноцтой надад санагдаж байгаа нэг зүйл нь юу вэ гэхлээр бидний үндсэн 2 асуудал бол хувьцаа эзэмшигчдийн зээлийн хүүг бууруулах, нөгөөдөх нь 2-т Онтрэгийн Монгол Улсын төрийн эзэмшлийг тогтоох буюу энэ шинэ хөрөнгө оруулалтын гэрээ шаардлагатай. Гэтэл энэ захидал дээр Онтрэгийн тусгай зөвшөөрлийн шилжүүлгийн асуудлаар гэдэг ийм зүйлийг бичсэн байна. Тэгэхээр Засгийн газрын ажлын хэсгээс Онтрэгийн асуудал дээр, энэ чинь шал 2 өөр зүйл яриад байгаа байхгүй юу. Оюу толгой болохоор энэ чинь тусгай зөвшөөрөл шилжүүлнэ гэсэн ойлголт энд яриад байна л даа. Гэтэл бид өнөөдөр Монгол Улсад мөрдөгдөж байгаа хуулийн дагуу стратегийн ордын асуудал бол Улсын Их Хурлын бүрэн эрх гэж үзээд байгаа. Улсын Их Хурлын бүрэн эрх гэдэг чинь энэ бид ард түмнээ төлөөлөөд, Монгол Улсад ирэх өгөөжөө хэлэлцэх ёстой.../минут дуусав/

О.Батнайрамдал: Болормаа гишүүнд нэмэлт 1 минут.

Э.Болормаа: Тэгэхээр энэ нөгөө улс төрийн шинж чанартай захидлын хамгийн чухал зүйл бол бид энэ Онтрэ гэдэг асуудал дээр тэс хөндлөн 2 ойлголт яваад байна гэдгийг баталгаажуулж байна л даа. Бид тусгай зөвшөөрлийг нь шилжүүлэх асуудал энд яриагүй шүү дээ. Тийм болохоор Рио Тинто компанитай бид уулзалт хийж, энэ дээр яг олон нийтэд зөв ойлголтыг нь өгөх хэрэгтэй байна л даа. Энэ магадгүй бид хаалттай хурал хийвэл тал талдаа хэн, хэн хардагдана. Тийм учраас эдгээр зүйлийг нээлттэй ярилцах ёстой гэж бодоод байгаа юм. Эсвэл Засгийн газрын энэ ажлын хэсэгт орж байгаа, энэ хэлэлцээрт орж байгаа ажлын хэсэг энэ дээр тодорхой байр суурийг бидэнд хэлэх ёстой. Яагаад гэвэл энэ Түр хороон дээр бид шал өөр юм яриад байхад тэнд зөвхөн лицензийн шилжүүлэг ярьж байвал энэ бол Монгол Улсад маш хохиролтой зүйл ярьж байна гэж хувьдаа ойлгож байна.

О.Батнайрамдал: Бат-Эрдэнэ гишүүний микрофон.

Б.Бат-Эрдэнэ: Баярлалаа. Би нэг юм хэлмээр байгаа юм. Энэ манай Хянан шалгах түр хорооны үйл ажиллагаатай холбоотой асуудлаа бид нэг эргэж харах ёстой юм болов уу л гэж зүгээр би ний нуугүй хэлэхэд бодож байна. Үгүй ээ үгүй, та үг сонсох ёстой Түр хорооны гишүүдээс. Та хэтэрхий их попорч байна, хэтэрхий их попорч байна. Үгүй ээ үгүй, та Түр хорооны даргын хувьд биднээс үг сонсож явах юм уу, явахгүй юм уу, эсвэл энэ попролтоо үргэлжлүүлэх юм уу? Сая энд асуусан гишүүдийн асуултад хариулж байгаа хариултууд чинь зүгээр л та хариуллаа шүү дээ, би үгээ хэлчих үү? Би энэ Түр хорооны гишүүний хувьд, Улсын Их Хурлын гишүүний хувьд өөрөө үгээ хэлж байна. Та хэтэрхий попорч байна. Энэ Улсын Их Хурлын гишүүний асуултад хариулахдаа өнгөрсөн хугацаанд ярьсан бүх юмыг дахин, дахин давтаж яриад, энийгээ та өөрөө рийл болгож гаргаж байгаа шүү дээ. Үнэн шүү дээ энэ. Би тан руу ерөөсөө дайраагүй.

Би энэ Оюу толгой компанитай холбоотой асуудал дээр маш шүүмжлэлтэй хандаж байгаа, та өөрөө мэдэж байгаа. Та бүхний яриагүй болгоныг би бас тодорхой хэмжээнд гарч ярьж байгаа шүү, 2018 оны асуудал, 2025 оны асуудал, 2014 он, 2025 он гээд Засгийн газартай холбоотой асуудлуудыг хөндөж байгаа шүү дээ. Тэгээд энэ дээр чинь биччихсэн байна шүү дээ даргаа, тантай холбоотой асуудлыг. Та уул нь энийг олон нийтэд, хэвлэл мэдээлэлд гарч ярихаасаа илүүтэйгээр, попрохоосоо илүүтэй хууль хяналтын байгууллагад өөрөө тухайн

үедээ тусад нь хандаад явчихвал энэ үйл ажиллагааны цар хүрээ чинь өөрөө арай илүү өөр түвшинд явах байсан юм биш үү гэж би зүгээр бодож байгаа нэг.

2 дугаарт бид Засгийн газар дээр ямар үйл ажиллагаа, ямар хэлэлцээр, ямар юм явж байгааг бид ний нуугүй хэлэхэд мэдэхгүй байна шүү дээ. Өнөөдөр Түр хорооны үйл ажиллагаа энэ Оюу толгой компаниар дамжуулж попорно гэхээс илүүтэй, олон нийтэд өөрсдийгөө таниулна гэхээс илүүтэйгээр мэргэжлийн чиг шугам дээр байгаасай гэж хүсэж байгаа юм. 89 гишүүн бидний 11 гишүүнийг сонгож, энэ түр хороо Хянан шалгах түр хороонд оруулахдаа мэргэжлийн түвшинд ядаж нэг талдаа, нөгөө талдаа эрх ашиг, илүү, дутуу асуудалд орооцолдоогүй гэж бодож биднийг анх сонгогдсон гишүүдийг оруулсан шүү дээ. Тан руу ерөөсөө дайраагүй шүү Батнайрамдал гишүүнээ. Та хүний үг авах ёстой.

Хяналтын түр хорооны үйл ажиллагаа ийм байдлаар үргэлжилбэл энэ оны төгсгөл гэхэд энэ хяналтын Хянан шалгах түр хорооноос олигтой үр дүн гарахгүй. Энийг би таныг анхаарч авч үзээсэй гэж бодож байна. Попротуудаа зогсоомор байна. Тэр их гоё, гоё рийлүүдээ зогсоомор байна. Бодит нөхцөл байдлыг бид, ялангуяа энэ Түр хорооныхоо хурал дээр ярьдаг баймаар байна. Тэрнээс биш энд орж ирчхээд бие биедээ хариулаад, тэндээ рийлдээ зориулаад хүчтэй, хүчтэй үгээр бид ярьдаг баймааргүй байна. Та рийл хийнэ шүү дээ одоо. Үгүй ээ тэгээд. Та бидний өмнө попорч яах гээд байгаа юм бэ, та ажлаа хий л дээ.

О.Батнайрамдал: Ганзориг гишүүний микрофоныг өгье. Үг хэлэх гишүүд нэрсээ өгье, орсон уу? Ганзориг гишүүнээр тасалъя. Болормаа гишүүний микрофон.

Э.Болормаа: Энэ дээр бүгдээрээ ер нь хаана хаанаа жоохон ажил хэрэгч хандъя гэж дахиж нэг хэлье. Гишүүд маань ч гэсэн дотроо, энэ захидал дотор бүүр дахиад нэг зүйлийг хэлэхэд сүүлийн үеийн улс төрийн нөхцөл байдал гэдэг үг орсон байх шиг байсан. Энэ мэдээж аливаа ардчилсан улсад ардчилсан мэтгэлцээн явна, хэлэлцүүлэг болно. Бид энэ дээр санал зөрөлдөх юм байна, улс төрд бол байдаг л зүйл. Энэ бол Монгол Улс ардчилал хөгжсөн гэдгийг харуулж байгаа гэж бодож байна.

Харин яг энэ Оюу толгойн асуудал дээр Монгол Улсын Их Хурал нэгдмэл байр суурьтай байгаа гэдэг дээр би маш өндөр итгэлтэй байна. Яагаад гэвэл энэ Түр хороог байгуулахаар 89 Улсын Их Хурлын гишүүн гарын үсэг зурж, энэ Түр хороог байгуулсан. Бид энд зөвхөн өөрсдийгөө төлөөлөөд суугаагүй, 89 гишүүнийг, ингээд Монгол Улсын эрх ашгийн төлөө энд сууж байгаа ийм бүлэг хүмүүс байгаа. Тэгэхээр энэ дээр олон нийт буруу ойлголт битгий аваасай гэж хүсэж байна. Энэ асуудал дээр нэгдмэл байр суурьтай байгаа.

Харин дараагийн алхмуудаа би бол ажил хэрэгчээр нэг санал өгөөд байгаа нь Засгийн газрын ажлын хэсэгтэй бүгдээрээ ойлголт авах үүднээс, магадгүй Засгийн газрын тал юм чинь хаалттайгаар хурал зохион байгуулах нь зүйтэй байх. Засгийн газрынхаа ажлын хэсэгтэй саяын хэлсэн энэ зээлийн хүү дээр өнөөдөр олон нийтэд Жавхлан сайд мэдээлэл өгсөн учир тэр мэдээллийг авсан байгаа. Онтрэгийн асуудал дээр ялангуяа бид өөр байр суурьтай байх вий. Мэдээж дахин хэлэхэд Улсын Их Хурлаас Засгийн газар томилогддог. Тэгэхээр Улсын Их Хурлын Хянан шалгах түр хороо бол чиглэлээ өгч, мэдээллээ солилцох нь зүйтэй. Тэрнээс биш энэ 2 өөр институт биш шүү дээ, Улсын Их Хурлаас Засгийн газар томилогдож байгаа, Улсын Их Хурал энэ Оюу толгойн асуудал дээр нэлээн нэгдмэл байр суурьтай байгаа. Үүнээс зөрөөд Засгийн газрын ажлын хэсэг явж байх вий

мэдээллийн дутуу байдлаас болж. Тийм болохоор би энэ Хянан шалгах түр хорооны дараагийн алхмууд бол бид ажлын хэсгийнхэнтэйгээ мэдээллээ дахин солилцъё гэсэн ийм саналтай байна.

О.Батнайрамдал: Пүрэвдаваа гишүүний микрофон.

Д.Пүрэвдаваа: Энэ өдрийн мэндийг хүргэе. Нэг ийм зүйлийн нэг санал хэлмээр байна. Бид нэг энэ тодорхой хугацаагаар ингээд төлөвлөөд, энэ 10 дугаар сарын эхний хагаст ямар, ямар үр дүнд хүрэх ёстой байсан юм ажлын удирдамжуудаа тодорхой болгомоор байна. 10 дугаар сарын сүүлийн хагаст хэн, хэн юу хийх юм бүх зүйл чинь хуулийн хугацаатай байгаа шүү дээ. Эцсийн deadline миний ойлгож байгаагаар 12 сарын 31-нд нөгөө хүү ярих ингээд хуулийн хугацаанд бид өнгөрчихнө. 1 дүгээр үе шат буюу ямар ч байсан Засгийн газар 8 дугаар сард ажлын хэсэг байгуулаад, ямар ч байсан нэг шат ингээд үйл ажиллагаа эхэлсэн байна, сайшаалтай зүйлүүд байна.

Бид хэдийгээр ингээд Улсын Их Хурлын гишүүд олон нийтэд зөв дохио өгсний үндсэн дээр Засгийн газар ямар хойшлуулагдашгүйгээр ажлын хэсэг байгуулж, ингээд хэлэлцээрийн үе шатыг эхлүүлж байна гэж ойлгож байгаа. Бид энэ дээр ямар оролцоотой байх юм. 89 хүнийг төлөөлөөд 11 хүн байгаа. 11 хүн маань ямар эрх, үүрэгтэйгээр оролцох юм бэ? Өөр өөрсдийнх нь мэргэжлийн чиг хандлага нь эдийн засагчид нь хэд байгаа юм, хуульчид нь хэд байгаа юм, геологийнх нь хэд байгаа юм, тэр яг салбар салбарынхаа чиглэлээр өөрсдийн хувь нэмрээ оруулсан ажил үүргийн хуваарийг гаргавал яадаг юм бэ гэдэг нэг санал дэвшүүлмээр байгаа юм.

Тэгээд Их Хурал руу бид чуулган руу ямар асуудлыг авч орж ирэх юм, манай шинжээчид хэзээ үндсэн дүгнэлтээ гаргах юм, тийм биз дээ. Яг энэ нөгөө үе шат болгоноо бид календарьчилсан төлөвлөгөө гаргамаар байна ажлын хэсгийн даргаа. Тэгэхээр 11-үүлээ саналаа солилцоод, тэгээд заавал Түр хорооны ээлжит хурал гэхгүйгээр өглөөний цай уугаад ч байдаг юм уу бид цагаа хэмнээд, чуулгантай өдөр чинь өглөө 10-аас чуулган эхэлж байгаа, 5 дахь өдөр байлаа гэхэд бид нэн даруй хүмүүсийнхээ саналыг сонсоод, өглөө 8 цагт ирээд саналаа солилцож болно шүү дээ 11-үүлхнээ юм чинь. Тэгээд хэн, хэн ямар яг хүсэл сонирхолтой байгаа юм, тэгээд нөгөө календарьчилсан бүүр зайлшгүй өдийд, өдийд ийм, ийм шийдвэр гарах ёстой гэдгээ бид чинь дандаа нөгөө тэд хоногийн өмнө танилцуулагдсан байх ёстой, тэд хоногийн өмнө Байнгын хороодоор орсон байх ёстой гээд энэ чинь нөгөө Дэгийн тухай хуулиараа процессууд байгаа шүү дээ. Энэнтэйгээ уялдуулаад нэг ийм төлөвлөгөө, ажил үүргийн хуваарь бий болговол яадаг юм бэ гэдэг саналыг гаргаж байна. Баярлалаа.

О.Батнайрамдал: Зулпхар гишүүний микрофоныг өгье.

С.Зулпхар: Баярлалаа. Тодорхой асуудлуудыг бид яах вэ асуусан учраас асуулт дотор зарим зүйлийг санал болгож байна гэж ойлгох ёстой байх. Эн тэргүүнд нэг зүйлийг зориуд хэлмээр байна. Хэвлэлээр энэ цаашдаа мэдээлэл болоод талуудад очих байх. Монгол Улсын төр Улсын Их Хурал, Засгийн газар гаднын хөрөнгө оруулагчдын эрх ашиг, сонирхлыг ямагт хүндэтгэж, хамгаалж ирсэн. Тэгэхээр энэ байр сууриа цаашдаа ч гэсэн Монгол Улсын төр хадгална гэдэгт эргэлзэх зүйлгүй. Монгол бол ардчилсан, эрх чөлөөт ийм улс орон учраас энэ тал дээр бат зогсож байгаа гэдгийг зориуд хэлмээр байна.

2 дахь зүйл манай Түр хорооны хуралдаанууд өнгөрсөн хугацаанд болсон маш үр дүнтэй, ажил хэрэгч болсон. Энийг үгүйсгэж ерөөсөө болохгүй. Яагаад гэхлээр зэрэг бид өнгөрсөн хугацаанд холбогдох талуудаас мэдээллээ сонсоод, тодорхой жишээ нь ойлголтуудыг авсан, тэрэнтэй холбоотой тодорхой тооцоо судалгаануудыг ч гэсэн сонссон, дүн шинжилгээнүүдийн үр дүнгүүдийг эхнээс нь сонсчихсон байгаа. Тэгэхлээр өнөөдрийн хуралдаан бид нэг ийм өнгөрсөн хугацаанд ямар нэгэн юм хийгээгүй явж байгаад гэнэт Оюу толгой компанийн төлөөлөл ирэх байсан чинь ирээгүйгээс болоод бид ингээд ажил маань зогсчихсон юм шиг, нэг бол зогсох юм шиг, гацчихсан юм шиг, гацах юм шиг байдлаар ойлгож ерөөсөө болохгүй. Цаашдаа энэ явна.

Монгол Улсын Их Хурал бол төрийн эрх барих дээд байгууллага, төрийн эрх барих дээд байгууллагын өөрийнх нь зохион байгуулалтын хэлбэр нь болсон Түр хороо нь тодорхой асуудлаар мэдээлэл сонсох, дүн шинжилгээ сонсох, үнэлэлт дүгнэлт өгөх, тэгээд энэтэй холбоотой тодорхой чиглэл гаргах өөрийн гэсэн бүрэн эрхтэй учраас энэ ажлаа л хийж байгаа гэдгийг заавал хэлмээр байна. Тэгэхлээр энэ дээр Батнайрамдал дарга бол энэ санаачилгыг анх гаргаад, тэгээд энэний дагуу манай 89 гишүүн нэгдээд, энэнтэй уялдсан байдлаар өнөөдөр Түр хороон дээр 11 гишүүн маш идэвхтэй ажиллаж байна. Бидний байр суурь нэгдмэл байгаа гэдгийг дахин илэрхийлж байна. Бидэнд тодорхой зүйлүүдээр санал зөрөлдөх, бие биедээ тодорхой зүйлээр энэ асуудлыг анхааръя гэдэг санал хэлж болох хэдий ч гэсэн бидний байр суурь нэгдмэл байгаа шүү гэдгийг талуудад илэрхийлье гэж байгаа юм.

Нөгөөтээгүүр Оюу толгой компани яах вэ мэдээлэл, мэдэгдэл гаргасан байж болно. Бидэнд албан бичгээр тодорхой саналаа илэрхийлсэн байж болно. Энэ бол хуулиар олгогдсон эрх нь. Гэсэн байлаа гэх нь энэ бол төрийн эрх барих байгууллагын тодорхой үйл ажиллагааг тасалдуулах үндэслэл болохгүй. Ямар нэгэн байдлаар шалтаг болохгүй. Хэрвээ тодорхой нөхцөл байдал байгаа бол энийг хянан шалгах, хянан шалгах чиг үүрэг бүхий Түр хорооны ажлын албатай ярьж, энэнтэй уялдсан байдлаар зохион байгуулалтаа хийх бас үүрэг нь бий. Хэрвээ тэдний жишээ нь компани дээр ямар нэгэн байдлаар, тэдний жишээ нь компанийн үйл ажиллагааг тасалдуулах, тэрнээс гадна жишээ нь иргэдийн эрх, эрх чөлөөнд халдах ямар нэгэн үйл ажиллагаа болсон бол энийг хууль хяналтын байгууллагаар шалгуулаад, энийгээ тогтоолгох нь тэдний эрхийн асуудал. Нөгөөтээгүүр Монголын төрийн байгууллагуудын үүрэг байгаа учраас энэ дээр өөрсдөө анхаар гэж байгаа юм.

Цаашлаад бид мэдээж хэрэг бүх зүйлээ өөрсдөө бид мэдэж хянаж байгаа. Хянаж байгаа гэдэг нь бидний үүрэг, Улсын Их Хурлын гишүүдийн үүрэг бол бүх мэдээллийг авах, мэдээлэлтэй уялдсан байдлаар үйл ажиллагаагаа зохион байгуулахад идэвхтэй оролцох. Засгийн газар дээр ажлын хэсэг байгуулагдсан бас энэ шалтгаан нь Улсын Их Хурлын энэ Түр хорооны хийж байгаа ажилтай уялдуулсан байдлаар Засгийн газар шуурхай ажиллах ийм чиг үүргийн дагуу л ажиллаж байгаа. Тэгэхээр Засгийн газрын ажиллаж байгаа, тэндээс ажлын хэсгүүдийн ямар явцтай байгаа талаарх мэдээллийг бид авч байгаа, цаашдаа ч энэ мэдээллээ авна. Тэгэхлээр бидний зорилго бол Оюутолгой компанийг энэ дээр ирээд бидэнтэй мэдээллээ нэгтгээч, ярьж байгаа зүйл, хэлэлцэгдэж байгаа зүйл дээр тодорхой тайлбараа өгөөч л гэсэн ийм байр суурьтай байгаа шүү гэдгийг хэлье. Би 1 минутаа нэмээд авчхаж болох уу дарга?

О.Батнайрамдал: Зулпхар гишүүнд нэмэлт 1 минутыг өгчихье.

С.Зулпхар: Нөгөөтээгүүр би Болормаа гишүүнтэй санал нэг байна. Сая энэ Оюу толгой компанийн бидэнд ирүүлсэн мэдэгдэл дээр их ноцтой юм бол байна шүү. Юу гэсэн гэхлээр зэрэг энэ Онтрэ-гийн тусгай зөвшөөрлийг шилжүүлэх асуудлаар бид зарчмын шийдэлд чиглэсэн яриа хэлэлцээ хийх зорилгоор Засгийн газрын холбогдох ажлын хэсгүүдтэй хамтран ажиллах үүрэг, амлалтаа хэвээр хадгалж байна гэж байна. Бидний байр суурь бол тийм биш байгаа. Энэ зөвшөөрөл шилжүүлэх тухай асуудал биш. Энэ бол стратегийн ач холбогдолтой орд дээр бид дахин хэлэлцээр хийж, Монголын талын буюу энэ бид хувь эзэмшиж байгаа том төсөл шүү дээ. Энэнээс гадуур энэ асуудал дээр бид эрхээ хангуулах ийм зорилгыг тавьж байгаа шүү гэж байгаа юм. Эцсийн дүндээ нэг зүйлийг заавал ойлгох ёстой. Аливаа харилцаа эрх тэгш, харилцан ашигтай байх ёстой. Энэ төсөл дээр эрх тэгш байдал алдагдсан байна, харилцан ашигтай байдал бидний төсөөлж байснаас маш их алдагдсан байна гэдэг үүднээс энэ Түр хороо байгуулагдсан. Түр хороо яг тэр байр суурин дээрээ ажиллаж, энэнтэй уялдсан шийдвэрийг бүхий л түвшинд гаргуулах чиглэлээр идэвхтэй ажиллана гэдгийг илэрхийлье. Баярлалаа.

О.Батнайрамдал: Баярлалаа. Баярбаатар гишүүний микрофон өгье.

Б.Баярбаатар: Тийм. Манай Түр хороо байгуулагдаад нэлээд хугацаа өнгөрчихлөө. Тэгээд цаашаа их богинохон хугацаа үлдэж байх шиг байна. Өнөөдөр хүртэл бид шинжээч нараа томилоод ингээд л явж байна. Энэ үр дүн рүүгээ чиглэсэн байдлаар асуудалдаа нэлээн нухацтай хандаад явахгүй бол би сүүлдээ нэг ийм болгоомжлол төрөөд байна. Засгийн газар энэ оноогдсон үүргээ биелүүлэхгүй байсан, парламент Түр хороо байгуулж ажилласан, буцаад Засгийн газарт чиглэл өгсөн. 3, 4 сар болж байгаа. Тэгтэл нөгөө хуулийн хугацаа нь дуусаж байдаг гэдэг асуудал үүсэх вий дээ. Бүүр явж, явж нөгөө бидний ажил нэг жоохон бүтэл муутай болоод ирсэн чинь буруутан нь нөгөө энэ Түр хороо болж хувирах вий дээ гэдэг болгоомжлол байгаад байгаа юм.

Тэгэхээр одоо энэ үлдэж байгаа богино хугацаандаа энэ манай гишүүдийн хэлж байгааг зөвөөр ойлгоод ажлын хэсгийн дарга та хүлээж аваад, Бат-Өлзийн Бат-Эрдэнэ гишүүний хэлж байгаа хэдий ууртай хэлсэн ч гэсэн агуулгаараа бол зөв л юм хэлчихлээ. Бид энэ магадгүй Оюу толгой чинь өнөөдөр энэ парламентад ирж уулзахгүй байгаа шалтгаан нь өөрөө ч бас энэ байхыг үгүйсгэхгүй учраас дараа дараадаа ажлаа явуулах үүднээс бид заримдаа хойшоо 1 алхаж байж, урагшаа 2 алхах ч боломж байдаг. Тэгэхээр энэ зүйл рүүгээ нэлээд анхаармаар байна.

Өнгөрсөн хугацаанд Зулпхар гишүүн хэлж байна, нэлээн үр бүтээлтэй ажилласан. Тэр мэдээлэл юмнуудаа бид сайн авчихсан. Одоо энэ шинжээч нартайгаа бид, шинжээч нартайгаа ер нь уулзаж болдог юм уу, болдоггүй юм уу, энэ чинь ажил юу Түр хороогоороо. Энэ чинь уулзаад ийм ажил явж байна, ингэж байна гээд нэг явцын мэдээллээ сонсоод, энэ дээр ингээд нэг ийм ажлын хэсгийн дарга, Түр хорооны дарга та бид өнгөрсөн хугацаанд ийм, ийм ажлуудыг хийчхэж, одоо энэ дээр явж байна, ингээд үлдсэн хугацаанд ийм, ийм ажлуудыг хийнэ, ийм, ийм бичиг цааснууд дээр ингэж ажилласан, ийм, ийм фактууд илэрлээ, ийм, ийм хуулийн зөрчлүүд гарч ирлээ, энэ дээр ингээд цаашаа ийм, ийм арга хэмжээнүүд авна гээд.

Тэгээд явж, явж бид ингээд Түр хорооноос чинь нэг ийм л цаас гарах байхгүй юу, ийм 2 хуудас цаас л гарна. Хурлаа хийнэ, протокол үйлдэнэ. Тийм. Тэгэхээр нөгөө энэ цаас маань өөрөө нийт ард түмний эрх ашгийг хангасан ийм цаас гарах ёстой учраас бид энэ дээрээ нэлээн тийм судалгаатай, системтэй ажиллаач гэдэг л асуудал байгаад байгаа юм. Тэгэхгүй бол манай гишүүдийн зарим бухимдаад

байгаа нь зөв л дөө. Ингээд сүүлийн 2 долоо, 14 хоногийг бид ингээд алдчихаж байгаа байхгүй юу. 14 хоног Оюу толгой ирсэнгүй, Оюу толгой ирсэнгүй гээд алдаад яваад байгаа нь өөрөө хайран л 14 хоног болчихож байгаа юм л даа. Энэ хооронд чинь бид Оюу толгой ирэхгүй юм байна гээд бид өөрсдөд өгөгдсөн тэр хэдэн хуудас материал ч гэлээ ирүүлчихсэн гээд бичиг дээрээ байна лээ шүү дээ, тэр өгөгдөл дээрээ бид өөрсдөө ажиллаад, юмнуудаа боловсруулаад ингээд явна.

Өнгөрсөн хугацааны материалыг нь, жишээлбэл би өнгөрсөн хугацааны энэ 3 тогтоолыг үзэхэд л энэ үг, үсгээр нь мөлжихөд аягүй олон асуудал байж байгаа байхгүй юу. Бараг энэ 3 тогтоолын хүрээнд ажиллахад л бараг, үргэлжлэл шүү дээр нь энэ чинь бидний хүрээнд хамаарахгүй байж болно, тэгэхдээ энэ чинь нэг л асуудлын нөгөө еэвэнгийн 2 тал гэдэг шиг л байхгүй юу. Энэний л үргэлжлэл бид. Энэ 3 тогтоол чинь яг уялдаатай явчихсан байгаа байхгүй юу. Эхнийх нь гараад л, тэрний дараагийн тогтоол нь өмнөх тогтоолоо хэрэгжүүлэхийн тулд өмнөх тогтоолынхоо он сар, дэс дугаарыг давтаад л, дараагийнх нь Түр хороо байгуулагдаад л, Түр хорооны өмнөх 2 тогтоолоо дурдаад л, тэгээд хэрэгжилтийг хангаад, гүйцэтгэлээ ингэж тооцъё л гээд ингээд явчихсан байдаг.

Гэтэл эндээс нь хэрэгжсэн зүйл хомс байгаад байгаа нэг ийм асуудал байгаа юм. Тэгэхээр манай энэ Түр хороо эндээс тийм тусдаа асуудал бол ер нь байхгүй. Онтрэ бол тусдаа байж магадгүй. Тэгэхдээ энэ дээр ч гэсэн Онтрэ-г дурдчихсан байна лээ гэдгийг саналын хувьд хэлье. Баярлалаа.

О.Батнайрамдал: Баярлалаа. Ганзориг гишүүн, гишүүний микрофон.

П.Ганзориг: Би өнөөдөр энэ Түр хороон дээр болсон 2 асуудлыг онцолж дурдмаар байна. Нэгд, Хянан шалгах түр хорооны ажил бас ажил хэрэгч, үр дүнтэй явж байгаа гэдгийг хэлье. Яагаад вэ гэхээр Хянан шалгах түр хороо ажиллаж эхэлснээс хойш энэ Засгийн газрын ажлын хэсгийн ч гэсэн үйл ажиллагаа их эрчимжсэн. Эхнээсээ үр дүн, нааштай үр дүнгүүд ярилцаад явж байгаа гэж ойлгож байгаа. Тийм болохоор Хянан шалгах түр хороон дээрээ бид яах вэ цаашдаа анхаарах зүйлүүд байна. Тэрийгээ анхаараад явах ёстой.

Тэгээд 1 зүйлийг бид анхаармаар байна. 2017, 2018 оны үед яг энэ зээлийн хүүг бууруулах гэрээний боломж байсан хэдий ч Монгол Улс ашиглаж чадаагүй. Яг тэр үед улс төр нь бас л ийм тогтворгүй, бужигнаантай байж байгаад энэ том боломжийг алдсан. Тэгээд өнөөдрийн нөхцөл байдал ч гэсэн тиймэрхүү өнгө аястай, ирсэн бичгийнх нь хариу хүртэл тийм. Өөрөөр хэлбэл улс төрийн нөхцөл байдал богино хугацаанд өөрчлөгдөж байгаа болохоор бид очиж тайлбар хийхгүй гээд. Энэ Монгол Улсын төр засаг улс төрийн нөхцөл байдал яаж ч явж байсан төрийн ажил тасралтгүй явж байгаа. Тийм болохоор би энэ 2 дахь асуудал буюу Оюу толгой өнөөдрийн энэ Түр хорооны хурал дээр өөрсдөө ирж мэдээллээр хангах үүрэгтэй. Энэ чинь Монгол Улсын 34 хувийг нь эзэмшиж байгаа, Монголын 3,5 сая хүний оролцоотой компани шүү дээ. Түүгээрээ үр ашгийг нь хүртэх ёстой компани. Гэтэл хаа хамаагүй хөндлөнгийн компанийг дуудаад байгаа юм шиг байдлаар ингэж хариуцлагагүй, үл хүндэтгэсэн байдалтай хандаж болохгүй гэж бодож байна. 2 дахь удаагаа шүү. Эхний удаа асуудлыг нь ойлгоно.

Тэгэхээр цаашдаа бид энэ хэрээс хэтэрсэн Монгол Улсын Их Хурлын үйл ажиллагаанд саад хийж байгаа энэ байдлыг ийм байдлаар нь өнгөрөөж болохгүй. Энийгээ бид хуулийн дагуу шахаж, шаардаж ажиллах ёстой гэж бодож байна.

Оюу толгойтой холбоотой асуудал дээр мэдээж энэ зээлийн хүүгийн асуудал бүгд мэдэж байгаа. Монгол Улс баялгаа ашиглуулаад, дээр нь өрөнд орж байгаа юм. Ийм утгагүй зүйлийг бид харилцан ашигтай, харилцан хүндэтгэлтэй гээд хүлээцтэй хандаад суугаад, 15 жил боллоо шүү дээ. Ингээд цаашаа яваад байж болохгүй. Өнөөдөр үндсэн зээл, хүүгийн төлбөр нийлээд 12 тэрбум долларын өртэй байж байна. Тэгээд энэ 11,1-ээрээ яваад байвал жил болгон 1,3 тэрбум доллар буюу 4,7 их наядын өр нэмэгдэнэ. 4,7 их наяд чинь 400 сургууль, цэцэрлэг бүрнээр нь жил болгон барих мөнгө шүү дээ. 1 их наядаар нь багш нарын цалингийн асуудлыг шийдчихнэ, 1 их наядаар нь эмч нарын цалингийн асуудал, 1 их наядаар нь тэтгэврийн асуудал шийднэ шүү дээ. Оюу толгойд төлж байгаа ганц жилийнхээ зээлийн хүүгээр л энэ олон бухимдаад байгаа асуудлуудыг шийдчихээр хэмжээний ийм асуудал байхгүй юу. Тийм учраас энэ олон улсын жишигт нь нийцүүлж, хүүг ядаж энэ зах зээлийнх нь зарчимд нийлүүлж, харилцан ашигтай болох ёстой гэдэг зүйлийг бид онцгой анхаарч, шахаж явах ёстой. Бууж байна гээд байгаа, буухдаа бид ямар, хэр хэмжээгээр бууруулах гэж байна гэдгийг энэ Түр хороо анхаарч шаардах ёстой гэж бодож байгаа.

2-т Оюу толгой дээр гарч байгаа шийдвэрүүд Монголын талын эрх ашиг, ялангуяа ТУЗ дээр ерөөсөө хангагдахгүй байгаад байгаа юм. 9 гишүүнтэй 3 нь Монголын тал, ямар ч нөлөө байхгүй. Гүйцэтгэх захирлаа солихдоо хүртэл хэлээгүй байж байгаад хурал дээр орж ирж байгаад сольж байгаа гэж байгаа байхгүй юу. Тэр чинь Монгол Улсын Засгийн газрыг төлөөлөөд, 34 хувийнхаа хувьцааг төлөөлөөд сууж байгаа хүмүүс шүү дээ. Энэ бол зүгээр жирийн компанийн хувьд ч гэсэн ийм байдаггүй зүйл шүү дээ, асар бүдүүлэг зүйл. Тэгэхээр бид 3,5 сая иргэнийг төлөөлөөд сууж байгаа Их Хурлын хувьд, Их Хурлаас гарсан Түр хорооны хувьд Монголынхоо талын улс орныхоо энэ зөрчигдөж байгаа эрх ашгуудыг хангуулах дээр бид илүү шаардлага тавиагүй шүү дээ, хуулиас гадуурх шаардлага тавиагүй, хуулийн дагуу, гэрээний дагуу хангуулах дээр шахаж, шаардаж ажиллах ёстой.

Тэгээд цаашдаа энэ Хянан шалгах хорооны үйл ажиллагаанд Оюу толгой талаас ирээд мэдээлэл өгөх байдлыг нь дахиж албан ёсоор шаардаж, ингэж ажилд саад учруулахгүй байдлаар хандахыг.../минут дуусав/

О.Батнайрамдал: Ганзориг гишүүнд нэмэлт минут.

П.Ганзориг: Түр хорооны, түр хороон дээр ирж мэдээллээр хангаж, шаардлагатай асуултуудыг, гишүүдийн асуултуудад хариулт, мэдээлэл өгөх шаардлагатай гэж үзэж байна. Бид яах вэ өөрсдөөс нь мэдээлэл авъя гэж байгаа шүү дээ. Тэгээд тодруулах зүйлүүдээ асууя. Тэгээд эндээс өөрсдийнхөө талын мэдээллийг өгч байж, энэ чинь тэгээд харилцан нээлттэй, хүндэтгэлтэй хамтын ажиллагаа цаашаа явна шүү дээ. Тэгээд нэг тал нь огт ирэхгүй, мэдээлэл өгөх боломжгүй гээд ингээд, ямар шалтгаантай нь тодорхойгүй байгаад байж болохгүй. Тэгэхээр цаашдаа Монгол Улсын Их Хурал, энэ Түр хороо ийм зүйлтэй эвлэрч болохгүй гэж бодож байна.

О.Батнайрамдал: Баярлалаа. Гишүүд асуулт асууж, үг хэллээ. Эцэст нь Хянан шалгах түр хорооны даргын хувьд нэг үг хэлье. Гишүүдтэй санал нэг байна. Ер нь Оюу толгойн асуудал шийдэгдтэл бид тийм дардан замаар явахгүй. Олон асуудлууд бидний бодоогүй ч олон асуудлууд гарах байх. Гэхдээ нэг зүйл маш ойлгомжтой. Түр хороон дээрээ бид илэн далангүй ярьдаг, ямар ч асуудал тохиолдож байсан, бид ямар ч зүйлээр явж байсан Монгол Улсын эрх ашгийн төлөө бид бүгдээрээ баттай, хамтдаа зогсох болно. Монгол Улсын эрх ашиг бол нэг л эрх

ашиг байгаа. Засгийн газар хэлэлцээрт орно, Улсын Их Хурал хяналт шалгалтаа хийнэ. Гэхдээ бүгдээрээ Монгол Улсын эрх ашгийг төлөөлж байгаа субъектүүд бид хамтдаа ямар ч тохиолдолд нэг талдаа байна.

Мөн хамгийн гол нь хянан шалгах үйл ажиллагааны хэвийн үйл ажиллагаанд бид аль, аль талын бүх талын байр суурийг бид сонсох үүрэгтэй юм. Тэгэхээр тэр үүргээ л бид хэрэгжүүлэх хэрэгтэй байгаа юм. Энд оролцоотой бүх компаниудыг, бүх холбогдох байгууллагуудыг бид бүгдээрээ дуудаж байгаа. Тийм учраас Оюу толгой компани ч гэсэн өөрсдөө ирээд, танилцуулгаа хийгээд, мэдээллээ өгөх үүрэгтэй. Ингэснээрээ бас Хянан шалгах түр хорооны гишүүд ч гэсэн илүү тэнцвэртэй мэдээлэл авах тэр боломжийг заавал хангах ёстой юм. Тэрнээс биш улс төр ямар ч байж болно. Улс төрийн янз бүрийн зүйлээр явсан ч гэсэн бид Оюу толгойн асуудлыг цаг хугацаанд нь заавал шийдэх ёстой. Энэ өөрөө Монгол Улсын 3,5 сая иргэний хүлээлт байгаа. Энэ хүлээлтийг бид ямар ч бороотой ч, цастай ч бид бүгдээрээ давж гараад, заавал шийдэх ёстой байгаа.

Тийм учраас өнөөдөр 2 дахь удаагаа дуудаад, Оюу толгой компани ирсэнгүй. Энэ Хянан шалгах түр хорооны хэвийн үйл ажиллагаанд хүндэтгэлтэй хандаж, ирэх зайлшгүй шаардлагатай гэж үзэж байгаа. Тийм учраас өнөөдрийн Хянан шалгах түр хорооны хуралдааныг Оюу толгой компани дахин иртэл хойшлуулахаас өөр аргагүй ийм байдалд хүрч байна.

16.06 цаг

Энэ удаагийн хуралдаан үүгээр өндөрлөлөө.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА